

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Төлбөрийн акт	23
5.2 Албан шаардлага	23
5.3 Зөвлөмж	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	28

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АҮҮХ	Аж үйлдвэржилтийн үндэсний хороо
АҮЭБС	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15180
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДАШПҮРЭВ ТАНАА

2026.02.25 № 06/380
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 63,532.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшингээс давсан бөгөөд дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант хугацаанд ажиллагчидтай холбоотой 12,890.8 мянган төгрөгийн авлага, бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн 96,819.1 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 9,592.5 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, 118,220.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулалгүй, төсөвт өртгийг хуваан шууд гэрээ байгуулсан, 23,387.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харилцагч байгууллагаас шууд худалдан авсан;
- Төсвийн хөрөнгөөс 117,596.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6, 16, 24, 41, 70 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6, 18 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5, 10 дугаар заалтуудтай нийцээгүй,

санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албаны 2025 оны төсвийг яамны төсвийн шууд захирагчийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 493,119.9 мянган төгрөгийг төсөвлөж батлуулсан бөгөөд тайлант онд нийт 411,009.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох "Сонгон шалгаруулалтын журам"-ыг шинээр батлуулж, сонгон шалгаруулалтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлсэн ба тайлант онд нийт 88 хайгуулын тусгай зөвшөөрөл олгож, улсын төсөвт 94,000,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Ханбогд дүүрэгт гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажил" төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулж, "Геологийн судалгаа-шинжилгээний төв" ТӨҮГ-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна. Гэрээний дагуу 2023 онд 2,999,553.4 мянган төгрөгийн өртөг бүхий ажлыг гүйцэтгэж дууссан боловч уг ажил тайлант оны байдлаар дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэлтэй хэвээр байна.

Бусад асуудал

Яамнаас хэрэгжүүлж буй томоохон хөрөнгө оруулалтын төслүүд, тухайлбал үйлдвэрлэл, технологийн парк, зэс боловсруулах болон кокс-химийн цогцолбор зэрэг мега төслүүд 2025 онд үе шаттайгаар хэрэгжиж байна. Гэвч төслүүдийн гүйцэтгэлийн явц харилцан адилгүй, зарим төслийн барилга угсралтын ажил болон санхүүжилтийн график төлөвлөсөн хугацаанаас хоцорсон байна.

Тухайлбал авто зам, цахилгаан дэд станц, төмөр зам, ус хангамжийн зэрэг дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилт 20–100 хувийн хооронд хэлбэлзэж, зарим төсөлд хугацаа сунгах шаардлага үүсч, улмаар төсөвт өртгийн дарамт нэмэгдэх нөхцөл байдал ажиглагдаж байна.

Мөн Гашуунсухайт–Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр зам болон нүүрсний худалдаатай холбоотойгоор Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хооронд 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан хэлэлцээр, уг хэлэлцээрийг 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлаар соёрхон баталсан шийдвэр нь стратегийн өндөр ач холбогдолтой байна.

Энэхүү шийдвэр нь нүүрсний экспортын зохицуулалт, тээвэр-логистикийн хүчин чадлын төлөвлөлт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ирээдүйн орлого, зардлын бүтэц болон мөнгөн урсгалд бодитой нөлөө үзүүлэхээр байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,070,104,282.40	4,000,676,299.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,987,901.84	3,077,901.84
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,987,901.84	3,077,901.84
3121	Төгрөг	17,987,901.84	3,077,901.84
31211	Төрийн сангийн харилцах	17,987,901.84	3,077,901.84
33	АВЛАГА	14,637,078.40	12,890,877.56
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	14,637,078.40	12,890,877.56
34	УРЬДЧИЛГАА	237,198,250.00	70,735,200.00
34600	Урьдчилж гарсан зардал	220,798,250.00	63,428,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	16,400,000.00	7,307,200.00
34714	Томилолтын урьдчилгаа	16,400,000.00	7,307,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,800,281,052.16	3,913,972,319.84
351	Түүхий эд материал	179,760,150.00	318,298,150.00
35110	Тусгай зориулалттай материал	179,760,150.00	318,298,150.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	2,999,553,406.84	2,999,553,406.84
354	Хангамжийн материал	620,967,495.32	596,120,763.00
35410	Бичиг хэргийн материал	43,605,390.00	34,648,295.00
35420	Аж ахуйн материал	502,812,995.00	509,215,155.00
35430	Сэлбэг хэрэгсэл	696,300.00	696,300.00
35440	Түлш, шатах тослох материал	7,083,254.32	113,301.00
35470	Бусад хангамжийн материал	66,769,556.00	51,447,712.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	536,925,536.84	646,335,090.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	536,925,536.84	646,335,090.85
392	Биет хөрөнгө	338,581,207.65	436,873,253.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,700,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,975,000.11)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	778,353,040.08	911,769,940.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(569,339,009.80)	(678,091,206.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	459,358,533.27	568,327,233.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	(356,058,540.79)	(379,325,344.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	114,583,445.37	114,583,445.37
39215	Хуримтлагдсан элэгдэл	(93,775,760.37)	(102,125,313.90)
39217	Ном	1,734,500.00	1,734,500.00
393	Биет бус хөрөнгө	198,344,329.19	209,461,836.88
39301	Програм хангамж	-	134,997,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,575,115,523.57	1,575,115,523.57
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,376,771,194.38)	(1,500,651,186.69)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,607,029,819.24	4,647,011,390.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,770,410.00	215,427,554.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,770,410.00	215,427,554.56
413	Өглөг	2,770,410.00	215,427,554.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	9,592,504.56
4136	Бусад өглөг	2,770,410.00	205,835,050.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,770,410.00	205,835,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,604,259,409.24	4,431,583,835.53
51	Засгийн газрын хувь оролцоо	4,604,259,409.24	4,431,583,835.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	304,117,253.38	304,117,253.38
51101	Өмч: - төрийн	304,117,253.38	304,117,253.38
512	Хуримтлагдсан үр дүн	4,300,142,155.86	4,127,466,582.15
51210	Өмнөх үеийн үр дүн	4,300,142,155.86	4,300,142,155.86
51220	Тайлант үеийн үр дүн	-	(172,675,573.71)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,607,029,819.24	4,647,011,390.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,989,391,400.00	7,803,543,205.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	30,250.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	30,250.00
120009	Бусад орлого	00.00	30,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,989,391,400.00	7,803,512,955.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,989,391,400.00	6,458,436,150.15
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,989,391,400.00	6,458,436,150.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,345,076,805.76
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	70,263,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,274,813,805.76
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,292,530,208.18	7,976,218,779.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,292,530,208.18	7,976,218,779.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,147,375,208.18	7,680,580,953.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,971,786,745.10	4,334,538,182.90
210101	Үндсэн цалин	1,170,107,544.20	2,455,488,207.37
210102	Нэмэгдэл	430,024,866.90	883,043,479.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	223,235,000.00	640,836,000.00
210104	Урамшуулал	148,419,334.00	355,170,496.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	248,673,174.82	541,504,706.15
210201	Тэтгэврийн даатгал	170,630,363.27	370,770,875.60
210202	Тэтгэмжийн даатгал	20,074,160.40	43,620,103.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,090,476.96	22,549,134.08
210204	Ажилгүйдлийн даатгал	9,575,634.88	20,912,918.78
210205	Эрүүл мэндийн даатгал	38,302,539.31	83,651,674.68
2104	Хангамж, бараа материалын зардал	41,813,982.08	107,713,634.32
210401	Бичиг хэрэг	12,101,200.00	32,282,176.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	19,499,953.32
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,388,782.08	33,160,556.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	151,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,824,000.00	22,619,599.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	9,050,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	5,290,280.00
210604	Урсгал засвар	00.00	3,760,000.00
2107	Томилолт, зочны зардал	137,735,553.00	214,009,555.00
210702	Дотоод албан томилолт	137,735,553.00	213,289,555.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	720,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	393,499,260.20	1,020,943,258.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	393,340,326.20	829,420,036.35
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,934.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	152,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	191,371,222.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	353,866,492.98	1,452,821,336.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,198,900.00	1,184,112,790.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,274,000.00	735,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	208,393,592.98	267,973,545.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,155,000.00	295,637,826.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,155,000.00	285,829,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,155,000.00	12,792,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	134,000,000.00	256,050,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	16,987,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	9,808,826.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	696,861,191.82	(172,675,573.71)
5	НИЙТ ҮР ДҮН	696,861,191.82	(172,675,573.71)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,162,990,500.00	7,815,648,482.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,419,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	9,419,100.00
120009	Бусад орлого	-	9,419,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,162,990,500.00	7,806,229,382.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,962,990,500.00	6,460,762,850.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,962,990,500.00	6,460,762,850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000,000.00	1,345,076,805.76
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	70,263,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,274,813,805.76
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	389,726.46
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	389,726.46
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,020,063,930.00	7,830,558,482.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,020,063,930.00	7,830,558,482.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,453,338,448.60	7,540,520,530.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,617,765,283.34	4,312,591,299.69
210101	Үндсэн цалин	2,113,752,602.29	2,403,771,431.17
210102	Нэмэгдэл	815,916,605.18	874,470,918.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	409,794,693.45	638,574,879.39
210104	Урамшуулал	278,301,382.42	395,774,070.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	454,965,892.01	557,674,897.24
210201	Тэтгэврийн даатгал	308,663,192.01	387,003,009.09
210202	Тэтгэмжийн даатгал	36,575,800.00	43,859,579.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,287,800.00	21,669,399.72
210204	Ажилгүйдлийн даатгал	18,287,900.00	20,100,275.52
210205	Эрүүл мэндийн даатгал	73,151,200.00	85,042,633.44
2104	Хангамж, бараа материалын зардал	121,447,587.09	77,575,852.00
210401	Бичиг хэрэг	34,332,500.00	10,957,350.00
210402	Тээвэр, шатахуун	19,620,000.00	10,670,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,663,531.09	38,276,672.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,831,556.00	17,671,830.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	304,011,440.00	33,660,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,767,100.00	25,173,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,358,900.00	4,727,600.00
210604	Урсгал засвар	278,885,440.00	3,760,000.00
2107	Томилолт, зочны зардал	340,919,123.51	177,588,000.00
210702	Дотоод албан томилолт	340,919,123.51	177,588,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,357,161,132.65	960,982,947.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,238,233,778.65	847,788,201.52
210803	Даатгалын үйлчилгээ	1,426,920.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,934.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	117,341,500.00	113,194,746.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	257,067,990.00	1,420,446,734.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	209,832,990.00	1,419,711,734.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	47,235,000.00	735,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	566,725,481.40	290,037,951.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	514,015,000.00	277,897,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	120,708,000.00	8,200,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	258,592,000.00	256,050,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	134,715,000.00	13,647,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,827,481.40	12,140,951.31

**Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан**

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,827,481.40	12,140,951.31
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	883,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	883,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	142,926,570.00	(14,910,000.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	150,538,360.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	150,538,360.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	150,538,360.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	150,538,360.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(150,538,360.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(7,611,790.00)	(14,910,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,599,691.84	17,987,901.84
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,987,901.84	3,077,901.84

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	-	1,163,954,403.75	1,468,071,657.13
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,117,253.38	-	1,163,954,403.75	1,468,071,657.13
7	Тайлант үеийн үр дүн	-	-	2,926,433,027.25	2,926,433,027.25
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	-	4,300,142,155.86	4,604,259,409.24
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,117,253.38	-	4,300,142,155.86	4,604,259,409.24
8	Тайлант үеийн үр дүн	-	-	(172,675,573.71)	(172,675,573.71)
9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	-	4,127,466,582.15	4,431,583,835.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,685,094,600.00	6,458,436,150.15	226,658,449.85	96.6
12	Татварын бус орлого	6,685,094,600.00	6,458,436,150.15	226,658,449.85	96.6
122	Тусламжийн орлого	6,685,094,600.00	6,458,436,150.15	226,658,449.85	96.6
122005	Төсвөөс санхүүжих	6,685,094,600.00	6,458,436,150.15	226,658,449.85	96.6
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,685,094,600.00	6,458,436,150.15	226,658,449.85	96.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,685,094,600.00	6,458,436,150.15	226,658,449.85	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,388,283,000.00	6,180,539,150.15	207,743,849.85	96.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,312,591,800.00	4,312,591,299.69	500.31	100.0
210101	Үндсэн цалин	2,356,703,400.00	2,403,771,431.17	(47,068,031.17)	102.0
210102	Нэмэгдэл	987,200,600.00	874,470,918.85	112,729,681.15	88.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	572,913,700.00	638,574,879.39	(65,661,179.39)	111.5
210104	Урамшуулал	395,774,100.00	395,774,070.28	29.72	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	569,696,700.00	557,674,897.24	12,021,802.76	97.9
210201	Тэтгэврийн даатгал	387,457,200.00	387,003,009.09	454,190.91	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	45,583,100.00	43,859,579.47	1,723,520.53	96.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,805,500.00	21,669,399.72	1,136,100.28	95.0
210204	Ажилгүйдлийн даатгал	22,770,200.00	20,100,275.52	2,669,924.48	88.3
210205	Эрүүл мэндийн даатгал	91,080,700.00	85,042,633.44	6,038,066.56	93.4
2104	Хангамж, бараа материалын зардал	84,026,100.00	77,575,852.00	6,450,248.00	92.3
210401	Бичиг хэрэг	14,953,900.00	10,957,350.00	3,996,550.00	73.3
210402	Тээвэр, шатахуун	11,222,600.00	10,670,000.00	552,600.00	95.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,908,100.00	38,276,672.00	1,631,428.00	95.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,941,500.00	17,671,830.00	269,670.00	98.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,055,500.00	33,660,800.00	14,394,700.00	70.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,173,200.00	25,173,200.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,932,300.00	4,727,600.00	13,204,700.00	26.4
210604	Урсгал засвар	4,950,000.00	3,760,000.00	1,190,000.00	76.0
2107	Томилолт, зочны зардал	162,678,400.00	162,678,000.00	400.00	100.0
210702	Дотоод албан томилолт	162,678,400.00	162,678,000.00	400.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,135,381,000.00	960,982,947.52	174,398,052.48	84.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,020,098,500.00	847,788,201.52	172,310,298.48	83.1
210803	Даатгалын үйлчилгээ	1,791,800.00	00.00	1,791,800.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,300.00	00.00	216,300.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	78,300.00	00.00	78,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	113,196,100.00	113,194,746.00	1,354.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,853,500.00	75,375,353.70	478,146.30	99.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,118,500.00	74,640,353.70	478,146.30	99.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	735,000.00	735,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	296,811,600.00	277,897,000.00	18,914,600.00	93.6

**Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	296,811,600.00	277,897,000.00	18,914,600.00	93.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,200,000.00	8,200,000.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	258,530,200.00	256,050,000.00	2,480,200.00	99.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,081,400.00	13,647,000.00	16,434,400.00	45.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	90	90	-	100.0
620001	Удирдах ажилтан	21	21	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	65	65	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		1,345,076,805.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,345,076,805.76
122	Тусламжийн орлого		1,345,076,805.76
1221	Хандив тусламж /дотоод/		1,345,076,805.76
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,345,076,805.76
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		70,263,000.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,274,813,805.76
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,345,071,380.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,345,071,380.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,345,071,380.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,345,071,380.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,345,071,380.76

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь салбарын бодлого, стратеги, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгож нэгдсэн удирдлагаар хангах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, судалгаа-инновац, дэвшилтэт технологи, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, аж үйлдвэр, геологи, уул уурхай, цөмийн энерги, газрын тосны салбарын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, төсөв санхүү, эрсдэлийн удирдлага, цахим шилжилтийг зохион байгуулж ногоон хөгжлийг дэмжин хэрэгжүүлэх, мөн тэдгээрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Эрхэм зорилго нь “Аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрдэс, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, газрын тосны боловсруулах үйлдвэрийг байгуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон бөгөөд үндсэн чиг үүргийг дараах байдлаар хэрэгжүүлдэг. Үүнд:

- Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого, стратегийг тодорхойлж, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах, салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, судалгаа, мэдээллээр хангах, инновац шингэсэн тэргүүний техник технологи дамжуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулахад ногоон хөгжлийг дэмжих;
- Эрдэс баялгийн салбарын бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах, геологийн судалгаа болон цөмийн энерги, уул уурхайн чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг судлах, баялгийн нөөцийн ашиглалтын бодлого, чиглэлийг тодорхойлох, хувилбар боловсруулах, ногоон хөгжлийн бодлогод дэмжлэг үзүүлэх;
- Аж үйлдвэрийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдамжаар хангах, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах;
- Геологи, цөмийн энерги, уул уурхайн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдамжаар хангах, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах;
- Газрын тосны салбарын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, ашиглалт, олборлолт, экспортыг нэмэгдүүлэх, газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, бодлогын удирдамжаар хангах;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөлт хийж, зарцуулах, хэрэгжилт болон төсвийн нээлттэй байдалд хяналт тавих, тайлагнах. нэгдсэн удирдлагаар хангах, салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, цахим

шилжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах;

- Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, үнэлэлт дүгнэлт өгч, нэгдсэн удирдлагаар хангах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

- Төсвийн тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна. Тухайлбал: Төсвийн төлөвлөлт сул байснаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн, мөн төсвийн баримт бичгийн хугацааг богиносгон зохион байгуулалтын сахилга батыг сайжруулсан. Түүнчлэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс үл хамааран төсвийн бодлогын залгамж чанарыг хадгалах, эрх мэдлийн давхардлыг арилгах зохицуулалтыг тусгаснаар төсвийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн удирдлагын хяналтын орчныг бэхжүүлсэн байх;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг хязгаарлах, хэмнэлтийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн. Үүнд, зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүдэд нэмэлт хөлс, урамшуулал олгохыг хориглож, байгууллагын төсвөөр уралдаан тэмцээн, арга хэмжээ зохион байгуулах, семинар, хурал, томилолттой холбоотой зардлыг бууруулах, мөн албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулах замаар бичиг хэргийн болон шуудангийн зардлыг хэмнэх зохицуулалтыг хуульчилсан байх;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь дунд хугацааны төсвийн хүрээ, нэгдсэн төсвийн тэнцвэржилт, төсвийн тодотголын зохицуулалтыг бодит нөхцөлд нийцүүлэн уян хатан болгох, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс шалтгаалан төсвийн тогтвортой байдлын шалгуур зөрчигдөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн. Мөн төсвийн тогтвортой байдлын үзүүлэлт, тайлагналтай холбоотой зарим давхардсан заалтыг цэгцэлж, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгосон байх;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хэсэгчилсэн аудит хийх, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх, худалдан авах ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах ажлыг нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус яамны мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэн Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу баталгаажууллаа.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,981.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,987.9	3,077.9	(14,910.0)
Авлага	14,637.1	12,890.9	(1,746.2)
Урьдчилгаа	237,198.3	70,735.2	(166,463.1)
Бараа материал	3,800,281.1	3,913,972.3	113,691.3
Үндсэн хөрөнгө	536,925.5	646,335.1	109,409.6
Нийт хөрөнгө	4,607,029.8	4,647,011.4	39,981.6
Өр төлбөр	2,770.4	215,427.6	212,657.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,604,259.4	4,431,583.8	(172,675.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,607,029.8	4,647,011.4	39,981.6

Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлага дансны үлдэгдэл 1,746.2 мянган төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбоотой авлага 5,325.3 мянган төгрөгөөр хасагдаж, 1 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан нөхөж өгсөнтэй холбоотой байгууллагаас авах авлага 3,579.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 12,890.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 166,463.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд шилжүүлсэн томилолтын урьдчилгаа төлбөрөөс 9,092.8 мянган төгрөг, урьдчилж гарсан зардлаас 157,370.2 мянган төгрөгөөр хасагдаж, 70,735.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал худалдаж авсан 251,926.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 138,288.4 мянган төгрөгийн бараа материалыг албан хэрэгцээнд зарцуулж, 3,913,972.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 109,409.6 мянган төгрөгөөр өссөн нь 377,383.1 мянган төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авсан, ТӨБЗГ-ын 2025 оны "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" 66 дугаар тогтоолын дагуу 44,700.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг бүртгэлээс хассан, 646,335.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөр дансанд ажилчидтай холбоотой 9,592.5 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөг, байр ашиглалттай холбоотой 32,266.3 мянган төгрөгийн түрээсийн төлбөрт төлөх өглөг, гэрээний дагуу бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт төлөх 170,798.2 мянган төгрөгийн өглөг, нийт 215,427.5 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Биет бус хөрөнгөд нийт 137,359.5 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 3 нэр төрлийн программ хангамж ашиглагдаж байна. Үүнээс:

- 134,997.5 мянган төгрөгийн өртөгтэй үйлдвэрлэл, технологийн паркийн (ҮТП) нэгдсэн мэдээллийн сан;
- Санхүү, нягтлан бодох бүртгэлийн 1,133.0 мянган төгрөгийн өртөгтэй асчлус программ;
- Монгол бичгийн хөрвүүлгийн толь бичгийн 1,152.0 мянган төгрөгийн өртөгтэй программ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 9,208,931.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн төсвийн саналыг 1,545,715.1 мянган төгрөгөөр бууруулж, нийт 7,663,216.8 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнээс нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалт, хангамжийн материал, норматив зардал, эд хогшил, урсгал засвар, томилолт, бараа үйлчилгээний зардал болон урсгал шилжүүлгийг нийт 1,605,250.1 мянган төгрөгөөр бууруулж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 59,535.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн тодотголоор бараа, ажил, үйлчилгээний зардлыг 943,991.8 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 6,685,094.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр, батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс 6,470,570.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 6,458,436.1 мянган төгрөгийг зарцуулан, 12,135.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,458,436.1 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 35,433.6 мянган төгрөгөөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал 95,993.3 мянган төгрөгөөр, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын ажлын зардал 76,317.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал 16,434.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/		
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,368,184.5	5,332,750.9	35,433.6	99.3
2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	136,492.5	40,499.3	95,993.3	29.7
3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	391,858.9	391,858.9	-	100.0
4	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад	256,194.0	256,050.0	144.0	99.9
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	38,281.4	21,847.0	16,434.4	57.1
6	80809	Эмчилгээний төлбөр	2,336.2	-	2,336.2	-
7	82401	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал	491,747.1	415,430.1	76,317.0	84.5
Нийт дүн			6,685,094.6	6,458,436.2	226,658.4	96.6

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгадагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/135 дугаар тушаалаар яамны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталж, батлагдсан 99 орон тоог 9 хувь буюу 9 орон тоогоор цомхотгож, байгууллагын бүтцийг 6 газар 3 хэлтэстэй байхаар төсөвт нийцүүлэн өөрчилсөн байна. Яамны 2025 оны төсөвт цалингийн зардлыг 2,563,874.2 мянган төгрөгөөр баталсныг тодотголоор 207,170.8 мянган төгрөгөөр бууруулсан байна.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д ажилтнуудад олгох хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээг баталж, нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийг 30.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Тайлант онд хоол, унааны хөнгөлөлтийн зардалд 572,913.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 638,574.8 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч, төсвийг бодитой төлөвлөөгүйгээс нийт 65,661.1 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

3. Тайлант онд яамны батлагдсан төсвөөс нийт 19 удаагийн төлөвлөгөөт бус гадаад томилолтод 96,819.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд эдгээр зардлыг төсвийн

төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцож, төсвийн саналд тусган батлуулаагүйгээс бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас 27,235.6 мянган төгрөг, мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлын ангиллаас 10,941.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангиллаас 1,643.2 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлаас 56,891.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

4. Тайлант онд Удирдлагын академийн Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 6, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 3, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 9, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 7, Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулсан байна.

Бусад цаг үеийн шинжтэй 5 төрлийн сургалтыг зохион байгуулж, нийт 6,882.0 мянган төгрөгийн зарцуулсан байна. Үүнд судалгааны арга зүй эзэмших, төрийн худалдан авах ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал, ёс зүй, хувь хүний хөгжил, төрийн албан хэрэг хөтлөлт зэрэг сэдэвт сургалт хамарчээ.

5. Тайлант онд яамны үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор нийт 6 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 118,220.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- МУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн АҮЭБ салбарын судалгаа, статистик мэдээ, мэдээлэл бэлтгэх, олон нийтийг нээлттэй, ил тод мэдээллээр хангаж сурталчлан таниулах зорилгоор newslife.mn, mining.mn, livetv.mn, 24tsag.mn, mass.mn, tsenzuur.mn сайтад мэдээ, мэдээлэл байршуулахад 39,330.0 мянган төгрөг,
- АҮЭБЯ-ны үйл ажиллаатай холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэх, зөвшөөрсөн мэдээллийг tsenzuur.mn, 24tsag.mn, mining.mn, newslife.mn, zogii.mn, livetv.mn, tsahiur.mn, mass.mn, ubn.mn, zarig.mn, tsahimnews.mn сайтад байршуулахад 59,080.0 мянган төгрөг,
- Салбарын мэдээ, мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор tsahimnews.mn сайтад мэдээ, мэдээлэл байршуулахад 19,810.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу яам нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр болон аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хооронд байгуулсан “Интегра” төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт 70,263.0 мянган төгрөг, Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан Аж үйлдвэржилтийн үндэсний хорооны 2025 онд хэрэгжүүлэх аж үйлдвэржилтийн төслүүдийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулахад шаардагдах 1,274,813.8 мянган төгрөг, нийт 1,345,071.3 мянган төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.

Дээрх эх үүсвэрээс бараа үйлчилгээний бусад зардалд 1,345,071.3 мянган төгрөгийг зарцуулсан ба 11,769.9 мянган төгрөгийг тоног төхөөрөмж, 97,071.8 мянган төгрөгийг

тавилга, эд хогшил худалдан авах зардалд, 476,225.2 мянган төгрөгийг цалин, урамшуулал, нэг удаагийн тэтгэмжийн зардалд, 111,559.3 мянган төгрөгийг гадаад, дотоод албан томилолтын зардалд, 648,440.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд зарцуулж, үлдэгдэл 5.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны А/43 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Уг төлөвлөгөөнд төсвийн хөрөнгө оруулалтын 984,000.0 мянган төгрөг, урсгал төсвийн 231,920.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний 288,035.0 мянган төгрөг, нөөц сангаас 505,700.0 мянган төгрөг, нийт 2,009,655.0 мянган төгрөгийн санхүүжилтээр 18 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгасан байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/79 дүгээр тушаалаар дээрх худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан байна.

Төлөвлөгөөний дагуу нийт 9 удаа нээлттэй тендер сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, нийт 648,681.4 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна. Үүнд:

- Олборлох, үйлдвэрлэх ил тод байдлын санаачлагын 2024 оны нэгтгэл тайлан боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Эс Ай Си Эй” ХХК-тай 109,000.0 мянган төгрөгийн гэрээ;
- Аж үйлвэржилтийн үндэсний хорооны ажлын албаны байрны түрээсийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Раашбулаг” ХХК-тай 96,000.0 мянган төгрөгийн гэрээ;
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан, шалгарсан оролцогч “Андхайрхан” ХХК-тай 134,997.5 мянган төгрөгийн гэрээ;
- Багаж, техник, хэрэгсэлийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Монтех дистрибьюшн” ХХК-тай 99,999.9 мянган төгрөгийн гэрээ;
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний 3 багц бүхий тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан оролцогч “Хараат бус судалгааны арвис төв”-тэй 1 дүгээр багц 29,900.0 мянган төгрөг, 2 дугаар багц 19,900.0 мянган төгрөг, “Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв”-тэй 3 дугаар багц 49,900.0 мянган төгрөгийн гэрээ;
- Ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс Компьютер худалдан авах тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Саммит Компьютер Технологи” ХХК-тай 13,984.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан.
- Тавилга эд хогшлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Говьхангай буйдан” ХХК-тай 95,000.0 мянган төгрөгийн гэрээг тус тус байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төсвийн шууд захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үр ашиггүй зардал гаргахгүй байх, мэдээллийн аюулгүй байдлын хариуцлагыг байгууллагын одоогийн бүтэц, орон тооны хүрээнд тодорхой хуваарилах, нэвтрэх эрхийн хяналт болон хэрэглэгчийн үйлдлийн бүртгэлийг журамлан мөрдүүлэх, гэрээний дагуу гүйцэтгэж дууссан ажлын өртгийг зөв ангилан бүртгэх талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Я.Марал-Эрдэнэ нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/235 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,953,235.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 69,532.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон, хязгаарласан гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр, зочин төлөөлөгч хүлээн авах тайлант онд санхүүжүүлээгүй бөгөөд хэвлэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал батлагдаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, салбарын чиг үүргийн биелэлт, мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, холбогдох хууль тогтоомж, журам, дотоод зохицуулалтын шаардлагыг бүрэн хангаагүй зэрэг 6 зөрчил илэрсэн байна.

Эдгээр нь яамны хууль, эрх зүйн нийцэл, дотоод хяналт, удирдлагын хариуцлагын тогтолцоонд эрсдэл үүсгэж байгаа тул зөрчлийг арилгах, таслан зогсоох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2 албан шаардлага, 4 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 178 мэдээлэл байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Тус яам нь 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэн, Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Мөн Төрийн Аудитын байгууллагад аудит ирүүлсэн санхүүгийн тайланд тодруулга, тэмдэглэлийг иж бүрэн бэлтгэж, толилуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тодруулга, тэмдэглэлийг иж бүрэн бэлтгээгүй зөрчлийг таслан зогсоох тухай албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Тайлант хугацаанд яамнаас гаргасан захирамжлалын болон зохион байгуулалтын шинжтэй нийт 78 -А, 24-Б тушаалыг эрх бүхий албан тушаалтан гарын үсгийн дардсаар баталгаажуулсан байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг

хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина.", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолын хавсралт "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.7-д "захирамжлалын, зохион байгуулалтын болон мэдээлэл-лавлагааны баримт бичгийг хянаж, цахим баримт бичгийг цахим гарын үсгээр, цаасан баримт бичигт гарын үсэг зурж тамга, тэмдгээр тус тус баталгаажуулах", 8.1-т "Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 48.2-т зааснаас гадна дараах зүйлийг хориглоно", 8.1.3-т "байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын, зохион байгуулалт болон мэдээлэл-лавлагааны баримт бичгийг эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн дардсаар баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал, шийдвэрийн баталгаажуулалттай холбоотой дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулж, баримт бичгийн хүчин төгөлдөр байдалд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 3: Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоо хангалтгүй байгаа нь мэдээллийн системийн найдвартай ажиллагаа, өгөгдлийн хамгаалалт, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тодруулбал:

- Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам болон холбогдох хууль, эрх зүйн актуудыг бүх албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хянах, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна. Мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан томилоогүй бөгөөд хэрэгжилтийн хяналт, тайлагнал тогтмол хийгдээгүй;
- Сервер болон мэдээллийн бааз доголдсон үед үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх сэргээн босголтын нөөц систем, төлөвлөгөө боловсруулаагүй, баталгаажуулсан баримт бичиггүй байна. Мөн кибер халдлагын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (Incident Response Plan) батлагдаагүй бөгөөд туршилт, сорилт хийгдээгүй;
- Санхүүгийн болон бусад мэдээллийн системд нэвтрэх эрхийн хяналт сул, хэрэглэгчийн эрхийн түвшинг тодорхойлсон журам бүрэн мөрдөгдөөгүй байна. Хэрэглэгчийн үйлдлийн лог бүртгэл хангалтгүй, систем дотор хийгдсэн бүх үйлдэл, өөрчлөлт, гүйлгээг цаг хугацааны дарааллаар бүртгэж хадгалах зохицуулалт бүрдээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын 1.2, 2.1.2, 4.16, 4.17, 7.1 заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн аюулгүй байдлын хариуцлагыг байгууллагын одоогийн бүтэц, орон тооны хүрээнд тодорхой хуваарилж, эрх, үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусган баталгаажуулах, мэдээллийн системийн тасралтгүй ажиллагаа болон кибер халдлагын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, нэвтрэх эрхийн хяналт болон хэрэглэгчийн үйлдлийн бүртгэлийг журамлан мөрдүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал болон үндсэн хөрөнгийн дансадад аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 4,675,693.4 мянган төгрөгийн дүн бүхий 13 алдаа, зөрчил илэрсэн бөгөөд эдгээр асуудлын хэрэгжилт хангалтгүй 11 асуудлыг жилийн эцсийн аудитаар дахин хянан шалгаж, аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 60,809.4 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 465,853.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 10 албан шаардлага хүргүүлэн, 794,553.4 мянган төгрөгийн 6 асуудлаар зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 72.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

№	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	6	60,809.4	2	37,000.0	33.3
2	Албан шаардлага	10	465,853.0	9	465,853.0	95.0
3	Зөвлөмж	6	794,533.4	5	663,216.4	83.3
Нийт дүн		22	1,321,195.8	16	1,166,069.4	72.7

Тайлант оны аудитаар бүрэн хэрэгжээгүй нийт 4 төлбөрийн акт, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн шууд захирагчийн нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр тус тус шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

- Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор Аж үйлдвэржилтийн үндэсний хороог байгуулж, 2025 онд хэрэгжүүлэх аж үйлдвэржилтийн төслүүдийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулахад шаардагдах нийт 2,645,918.5 мянган төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас олгохоор шийдвэрлэсэн байна. Тус шийдвэр нь “Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасан төсөвт тусгагдаагүй, гэнэтийн болон зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлын үед ашиглах тухай шаардлагыг зөрчсөн ба тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 1,274,813.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, нийт 766,598.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 189,513.3 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

Яамны 2025 оны санхүүгийн байдлын тайлан дахь бараа материал, авлага, урьдчилгаа дансны эцсийн үлдэгдлийн дүн нь тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнгээс нийт 189,513.3 зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, УСНББОУС-1, 17 дугаар заалттай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 3,567,516.6 мянган төгрөгийн 12 зөрчил² илэрснээс, 1,130.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 566,833.2 мянган төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 2,999,553.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн 3,567,516.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/32, А/80, А/111 дүгээр тус тус тушаалын дагуу албан хаагчдад дотоод томилолтын зардал олгохдоо баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 1,130.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай"-г мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод томилолтын зардлыг илүү тооцож олгосон нийт 1,130.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" 66 дугаар тогтоолын дагуу "Засгийн газрын авто бааз" ТӨААТҮГ-т 0620УБМ улсын дугаартай тээврийн хэрэгслийг шилжүүлж, данс бүртгэлээс хассан байхад тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр тушаалаар баталсан "Авто зогсоол түрээсийн гэрээ"-ний дагуу 2025 оны 1, 2 дугаар улиралд нийт 2,112.0 мянган төгрөгийг авто зогсоолын түрээсийн төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Авто зогсоолын түрээсийн гэрээг цуцлаагүй, төлбөрийг шилжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3778 УКН улсын дугаартай "Nissan Patrol Y63" маркийн тээврийн хэрэгслийг сайдын албан хэрэгцээнд ашигласан бөгөөд уг тээврийн хэрэгсэлтэй холбоотой яамны төсөвт тусгагдаагүй 2,772.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт тусгагдаагүй зардал гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант оны эцэст нийт 12,890.8 мянган төгрөгийн авлага, 215,427.5 мянган төгрөгийн өр төлбөр өглөгийг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих," 70 дугаар зүйлийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны эцэст авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд төсвөөс нийт 19 удаагийн төлөвлөгөөт бус гадаад томилолтод 96,819.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд эдгээр зардлыг төсвийн төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцож, төсвийн саналд тусган батлуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төлөвлөлтийг бодит тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулах, зардлыг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах талаар албан шаардлага хүргүүлсэн

5. Тайлант онд гадаад томилолтын зардалд Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар тогтоосон зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 16,494.3 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт

яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын хэмжээ"-г мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан гадаад томилолтын зардлын хэмжээг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

6. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/118, А/119 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 23,387.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харилцагч байгууллагаас шууд худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

7. Тайлант онд яамны үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хуваах замаар нийт 6 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 118,220.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

8. Яам нь олон нийтэд мэдээлэл сурталчлах үйлчилгээ авахдаа гүйцэтгэгчийг тухайн ажлын мэргэжлийн чиглэл, салбарын хамаарал, туршлага, чадавхад үндэслэн сонгон шалгаруулах шаардлагыг хангаагүй, улсын бүртгэлд тусгагдсан үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хэвлэл мэдээ, мэдээлэл түгээх үйлчилгээтэй нийцэхгүй 4 хуулийн этгээдээр нийт 78,710.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх

талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, журмын дагуу үйл ажиллагааны чиглэлийг анхаараагүй, хянаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

9. Гадаад болон дотоод томилолтын зардлын зарцуулалттай холбоотой анхан шатны баримт, тухайлбал илтгэх хуудас, томилолтын тайлан, автомашин хөлсөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ, шатахуун худалдан авалтын баримт, жолоочийн замын хуудас зэрэг анхан шатны баримтын бүрдлийг хангуулж хүлээн авах, хянаж баталгаажуулах үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад болон дотоод томилолтын зардалтай холбоотой анхан шатны баримтын бүрдлийг / илтгэх хуудас, томилолтын тайлан, автомашин хөлсөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ, шатахуун худалдан авалтын баримт, жолоочийн замын хуудас/ хангуулаагүй, баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох тухай албан шаардлага хүргүүлсэн.

10. Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 23,809.4 мянган төгрөгийн дараах зөрчилд тогтоосон 4 төлбөрийн актыг барагдуулаагүй, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны Б/03 дугаар тушаалаар албан хаагчдын хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 85 аас доош оноо авсан 5 албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг олгохдоо маш сайн ангилалд хамрагдсан албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиар бодож олголгүйгээр 100 хувиар тооцож илүү олгосон 4,832.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Геологийн судалгааны ажилтай холбоотой онгоцны тийзний буцаалт 2,770.4 мянган төгрөг нь өмнөх онд байгууллагын дансанд андуурагдан орсон бөгөөд улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Геофизикийн цогцолбор судалгааны ажил нь 2023 онд хийгдэж дууссан бөгөөд захиалагчийн хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 15,217.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Цалингийн зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд тайлант онд албан хаагчдын цалин тооцохдоо томилолтоор явсан 9 албан хаагчдад хоол, унааны зардлыг давхардуулан тооцож олгосон 989.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;

- Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар үлдэх өртөггүй боловч үйл ажиллагаа нь хэвийн ашиглагдаж байгаа 195 ширхэг 711,820.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх тухай албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүрэгээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Аудит хийх журам”-ын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн нийт 4 төлбөрийн актыг барагдуулаагүй, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дуусаагүй үйлдвэрлэлийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ханбогд дүүрэгт гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажил” төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулж, “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна. Гэрээний дагуу 2023 онд 2,999,553.4 мянган төгрөгийн өртөг бүхий ажлыг гүйцэтгэж дууссан боловч уг ажил тайлант оны байдлаар дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэлтэй хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний дагуу гүйцэтгэж дууссан ажлын өртгийг стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн дуусаагүй үйлдвэрлэлийн данснаас шилжүүлж, зөв ангилан бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/					
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн байдлын тайлан /СТ-1/ дахь бараа материал, авлага, урьдчилгаа дансны эцсийн үлдэгдлийн дүн нь тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан байна.	1	189,513.3 ✓			1	189,513.3
Дүн		1	189,513.3			1	189,513.3

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/					
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дотоод томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 1,130.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,130.0	1	1,130.0		
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тушаалаар баталсан “Авто зогсоол түрээсийн гэрээ”-ний дагуу тус яаманд бүртгэлтэй 0620УБМ улсын дугаартай тээврийн хэрэгслийн авто зогсоолыг сарын 352.0 мянган төгрөгийн	1	2,112.0 ✓			1	2,112.0

	төлбөртэйгөөр түрээслэхээр гэрээ байгуулсан байна. Гэвч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" 66 дугаар тогтоолын дагуу уг тээврийн хэрэгсэл "Засгийн газрын авто бааз" ТӨААТҮГ-т шилжиж, яамны үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасагдсан байхад 2025 оны 1, 2 дугаар улиралд нийт 2,112.0 мянган төгрөгийг авто зогсоолын түрээсийн төлбөрт шилжүүлсэн байна.										
3	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3778 УКН улсын дугаартай "Nissan Patrol Y63" маркийн тээврийн хэрэгслийг сайдын албан хэрэгцээнд ашигласан бөгөөд уг тээврийн хэрэгсэлтэй холбоотойгоор яамны батлагдсан төсөвт тусгагдаагүй 2,772.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	2,772.0				1	2,772.0			
4	Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант оны эцэст нийт 12,890.8 мянган төгрөгийн авлага, 215,427.5 мянган төгрөгийн өр төлбөр өглөгийг үүсгэсэн байна	1	228,318.3				1	228,318.3			
5	Тайлант онд яамны батлагдсан төсвөөс нийт 19 удаагийн төлөвлөгөөт бус гадаад томилолтод 96,819.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд эдгээр зардлыг төсвийн төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцож, төсвийн саналд тусган батлуулаагүйгээс батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх зохицуулалт хангагдаагүй байна.	1	96,819.1				1	96,819.1			

6	Тайлант онд гадаад томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 16,494.3 мянган төгрөгийг олгосон байна.	1	16,494.3 ✓			1	16,494.3			
7	Аж үйлвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/118, А/119 дугаар тушаалаар төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 23,387.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харилцагч байгууллагаас шууд худалдан авсан байна.	1	23,387.3 ✓			1	23,387.3			
8	Тайлант онд яамны үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хуваах замаар нийт 6 байгууллагатай шууд гэрээ байгуулж 118,220.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.	1	118,220.0 ✓			1	118,220.0			
9	Яам нь олон нийтэд мэдээлэл сурталчлах үйлчилгээ худалдан авахдаа гүйцэтгэчийг тухайн ажлын мэргэжлийн чиглэл, салбарын хамаарал, туршлага, чадавхад үндэслэн сонгон шалгаруулах шаардлагыг хангаагүй бөгөөд улсын бүртгэлд тусгагдсан үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хэвлэл мэдээлэл, мэдээлэл түгээх үйлчилгээтэй нийцэхгүй 4 хуулийн этгээдээр нийт 78,710.0 мянган төгрөгийн ажил гүйцэтүүлсэн байна.	1	78,710.0 ✓			1	78,710.0			
10	Яам нь гадаад болон дотоод томилолтын зардлын зарцуулалттай холбоотой анхан шатны баримт.	1	-			1	-			



Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан

	тухайлбал томилолтын тайлан, автомашин хөлсөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ, шатахуун худалдан авалтын баримт, жолоочийн замын хуудас, илтгэх хуудас зэрэг нотлох баримтыг бүрэн бүрдүүлж хүлээн авах, баталгаажуулах, хянан шалгах ажиллагаа хангалтгүй, нягтлан бодогч анхан шатны баримтын бүрдэл, гүйлгээний үнэн зөв, бодит байдлыг шалган баталгаажуулах үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.																		
11	Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 23,809.4 мянган төгрөгийн дараах зөрчилд тогтоосон 4 төлбөрийн актыг барагдуулаагүй, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.																1		
12	2023 онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ханбогд дүүрэгт гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажил” төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулж, “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна. Гэрээний дагуу 2,999,553.4 мянган төгрөгийн өртөг бүхий ажлыг гүйцэтгэж дууссан боловч уг ажил тайлант оны байдлаар дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэлтэй хэвээр байна.	1	2,999,553.4														1	2,999,553.4	
Дүн		12	3,567,516.4	1	1,130.0	9	566,833.0	1	2,999,553.4	1							1	2,999,553.4	-

1.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/					
		Нийт зөрчил		Албан шаардлага		Үүнээс	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шилэн дансны цахим хуудсанд нийт 178 мэдээлэл байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	1	-		
	Дүн	1	-	1	-		
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэн, Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр хугацаа хоцроон ирүүлсэн байна. Мөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн Аудитын байгууллагад аудит хүргүүлсэн санхүүгийн тайланд тодруулга, тэмдэглэлийг иж бүрэн бэлтгэж, толилуулаагүй байна.	1	-	1	-		
2	Тайлант хугацаанд яамнаас гаргасан захирамжлалын болон зохион байгуулалтын шинжтэй нийт 78 'А', 24 'Б' тушаалыг эрх бүхий албан тушаалтан гарын үсгийн дардсаар баталгаажуулсан байна. Хяналт-шинжилгээний дүнгээс үзвэл эрх бүхий албан тушаалтны гаргасан баримт бичгийн хүчин төгөлдөр байдалд эргэлзээ үүсэх, дотоод хяналтын тогтолцоо сулрах эрсдэлтэй байна.	1	-			1	-
3	Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам болон холбогдох хууль, эрх зүйн актуудыг бүх албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хянах, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна. Мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан томилоогүй бөгөөд хэрэгжилтийн хяналт, тайлагнал тогтмол хийгдээгүй байна.	1	-			1	-
4	Сервер болон мэдээллийн бааз доголдсон үед үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх сэргээн босголтын нөөц систем, төлөвлөгөө боловсруулаагүй, баталгаажуулсан баримт бичиггүй байна. Мөн кибер халдлагын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (Incident Response Plan) батлагдаагүй бөгөөд туршилт, сорилт хийгдээгүй байна.	1	-			1	-
5	Санхүүгийн болон бусад мэдээллийн системд нэвтрэх эрхийн хяналт сул, хэрэглэгчийн эрхийн түвшинг тодорхойлсон журам бүрэн мөрдөгдөөгүй байна. Хэрэглэгчийн үйлдлийн лог бүртгэл хангалтгүй, систем дотор хийгдсэн бүх үйлдэл, өөрчлөлт, гүйлгээг цаг хугацааны дарааллаар бүртгэж хадгалах зохицуулалт бүрдээгүй байна.	1	-			1	-
	Дүн	5	-	1	-	4	-
	Нийт дүн	6	-	2	-	4	-





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ТАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 79/A0171239

Улаанбаатар хот

САГ - 2026/3/ИА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 1,130,000.00 /Нэг сая нэг зуун гучин мянган/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушгал "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай"-г мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, задгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/32, А/80, А/111 дүгээр тус тус тушаалын дагуу дотоод албан томилолтын зардалд илүү тооцож олгосон нийт 1,130,000.00 /Нэг сая нэг зуун гучин мянган/ төгрөгийн тооцооллыг хийж, гүйлгээг хянасан нягтлан бодогч С.Рагчаабазар, шийдвэр гаргасан Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дашпүрэв нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Akn2026\0225 САГ-48 Docx

1526160538



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 411/A0171239

Улаанбаатар хот

САГ - 2026/3/НА - СТА - ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэн, ирүүлсэн байна. Мөн Төрийн Аудитын байгууллагад аудит хүргүүлсэн санхүүгийн тайланд тодруулга, тэмдэглэлийг иж бүрэн бэлтгэж, толилуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тодруулга, тэмдэглэлийг иж бүрэн бэлтгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ март даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр.
Утас 51-261230

Z: Alban Shaardlaga 20260125 SAG-73.Docx

1526180877



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 412/А0171239

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА - СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр тушаалаар баталсан "Авто зогсоол түрээсийн гэрээ"-ний дагуу тус яаманд бүртгэлтэй 0620УБМ улсын дугаартай тээврийн хэрэгслийн авто зогсоолыг сарын 352,000.00 /гурван зуун тавин хоёр мянган/ төгрөгийн төлбөртэйгөөр түрээслэхээр гэрээ байгуулсан байна.

Гэвч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" 66 дугаар тогтоолын дагуу уг тээврийн хэрэгсэл "Засгийн газрын авто бааз" ТӨААТҮГ-т шилжиж, яамны үндсэн хөрөнгийн бүртгэлээс хассан боловч 2025 оны 1, 2 дугаар улиралд нийт 2,112,000.00 /хоёр сая нэг зуун арван хоёр мянган/ төгрөгийг авто зогсоолын түрээсийн төлбөрт шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өмчийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Яам нь авто зогсоолын түрээсийн гэрээг цуцлаагүй, төлбөрийг шилжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\125\SAГ-73.Docx

1526180879



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 413/А0171239

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА -СТА -ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3778 УХН улсын дугаартай "Nissan Patrol Y63" маркийн тээврийн хэрэгслийг сайдын албан хэрэгцээнд ашигласан бөгөөд уг тээврийн хэрэгсэлтэй холбоотойгоор яамны батлагдсан төсөвт тусгагдаагүй 2,772,000.00 /хоёр сая долоон зуун далан хоёр мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Яам нь батлагдсан төсөвт тусгагдаагүй зардал гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

М.Я.Ф.



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 414/А0171239

Улаанбаатар хот

САГ-2026/3/КА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант оны эцэст нийт 12,890,877.56 /арван хоёр сая найман зуун ерэн мянга найман зуун далан долоон төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгийн авлага, 215,427,554.56 /хоёр зуун арван таван сая дөрвөн зуун хорин долоон мянга таван зуун тавин дөрвөн төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Үүнд:

- Ажилчдаас авах авлага 878,769.98 /найман зуун далан найман мянга долоон зуун жаран ес төгрөг ерэн найман мөнгө/ төгрөг,
- Байгууллагаас авах авлага 12,012,107.58 /арван хоёр сая арван хоёр мянга нэг зуун долоон төгрөг тавин айман мөнгө/ төгрөг,
- Байр ашиглалттай холбоотой түрээсийн төлбөрт төлөх өглөг 32,266,300.00 /гучин хоёр сая хоёр зуун жаран зургаан мянга гурван зуун/ төгрөг,
- Гэрээний дагуу бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт төлөх өглөг 170,798,200.00 /нэг зуун далан сая долоон зуун ерэн найман мянга хоёр зуун/ төгрөг,
- Ажилчидтай холбоотой хувь хүний орлогын албан татварын өглөг 9,592,504.56 /есөн сая таван зуун ерэн хоёр мянга таван зуун дөрвөн төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 70 дугаар зүйлийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилдйн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-201230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-73.Docx

1526180883

1. Тайлант оны эцэст авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 415/A0171239

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд яамны батлагдсан төсвөөс нийт 19 удаагийн төлөвлөгөөт бус гадаад томилолтод 96,819,183.00 /Ерэн зургаан сая найман зуун арван есөн мянга нэг зуун наян гурван/ төгрөгийг зарцуулсан бөгөөд эдгээр зардлыг төсвийн төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцож, төсвийн саналд тусган батлуулаагүйгээс батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх зохицуулалт хангагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн", 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Яамны гадаад томилолтын зардлын төсвийг бодитой төлөвлөөгүйгээс зардлын эдийн засгийн ангилал зөрчин зарцуулалт гаргасан зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264239

Z: Alban Shaardlaga-2026/0125 SAG-73.Docx

1526180885



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 416/АД171239

Улаанбаатар хот

САГ - 2026/3/НА - СТА - ПИЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гадаад томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 16,494,372.00 /арван зургаан сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга гурван зуун далан хоёр/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын хэмжээ"-г мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн", 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант онд гадаад томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

АТД171239
9325021411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-73.Docx

1526180887



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 417/АД171239

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Яам нь гадаад болон дотоод томилолтын зардлын зарцуулалттай холбоотой анхан шатны баримт, тухайлбал томилолтын тайлан, автомашин хөлсөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ, шатахуун худалдан авалтын баримт, жолоочийн замын хуудас, илтгэх хуудас зэрэг нотлох баримтын шаардлагыг хангуулж хүлээн авах, бодит байдлыг шалган баталгаажуулах үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гадаад болон дотоод томилолтын зардалтай холбоотой анхан шатны баримтыг /томилолтын тайлан, автомашин хөлсөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ, шатахуун худалдан авалтын баримт, жолоочийн замын хуудас, илтгэх хуудас зэрэг/ бүрэн бүрдүүлж хүлээн аваагүй, баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-260230

Z:\Alban Shaardlaga\2026\0125_SAG-73.Docx

1526180889



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 418/АД/71239

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА - СТА - ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд яамны үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хуваах замаар нийт 6 байгууллагатай шууд гэрээ байгуулж 118,220,000.00 /нэг зуун арван найман сая хоёр зуун хорин мянган/ төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3. Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Alban Shuurdlogai\2026-0125 SAG-73.docx

1526180893



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 419/АД171239

Улаанбаатар хот

САГ - 2026 / 3 / НА - СТА - ТИ 3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Яам нь олон нийтэд мэдээлэл сурталчлах үйлчилгээ худалдан авахдаа гүйцэтгэгчийг тухайн ажлын мэргэжлийн чиглэл, салбарын хамаарал, туршлага чадавхад үндэслэн сонгон шалгаруулах шаардлагыг хангаагүй бөгөөд улсын бүртгэлд тусгагдсан үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хэвлэл мэдээлэл, мэдээлэл түгээх үйлчилгээтэй нийцэхгүй 4 хуулийн этгээдээр нийт 78,710,000.00 /далан найман сая долоон зуун арван мянган/ төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

- Лидерскай ХХК / Гадаад худалдаа, Барилгын засвар, засал чимэглэл/
- Мон Аэр Тур ХХК /Аялал жуулчлал, Олон улсын онгоцны тийз борлуулах үйлчилгээ, Агаараар ачаа тээвэр зуучлал, Барилгын засвар, засал чимэглэл/
- Зөв хандлага эерэг нөлөө НҮТББ /Эх орны хөгжил цэцэглэлт, нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахад залуусын оролцоог нэмэгдүүлэх, сургалт семинар зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах/
- Төв хөгжлийн цацрах гэрэл төв ТББ /Иргэдэд эрүүл мэнд, соёл урлаг, боловсрол, байгаль орчны чиглэлээр мэдээ, мэдээлэл өгөх, судалгаа хийх, сургалт явуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ижил зорилготой байгууллагуудтай хамтран ажиллах/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.6-д "төсвийг зорилго бусаар зарцуулсан", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\20260125\SAU-73.Docx

1526180895

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, журмын дагуу үйл ажиллагааны чиглэлийг анхаараагүй, хянаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 420/A0171239

Улаанбаатар хот

САГ - 2026 / 3 / НА - СТА - ТЦ 3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/118, А/119 дугаар тушаалаар төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 23,387,300.00 /хорин гурван сая гурван зуун наян долоон мянга гурван зуун/ төгрөгийн үндсэн хөрөнгийг харилцагч байгууллагаас шууд худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталла", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулалтыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮВЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 421/A0171239

Улаанбаатар хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 178 мэдээлэл байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал", 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд мэдээлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/, төсвийн нягтлан бодогч /С.Рагчаабазар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ

1526180897



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 422/АД171239

Улаанбаатар хот

САГ - 2026/3/НА - СТА - ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 23,809,400.00 /хорин гурван сая найман зуун есөн мянга дөрвөн зуун/ төгрөгийн дараах зөрчилд тогтоосон 4 төлбөрийн актыг барагдуулаагүй, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны Б/03 дугаар тушаалаар албан хаагчдын хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 85 аас доош оноо авсан 5 албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг олгохдоо маш сайн ангилалд хамрагдсан албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиар бодож олголгүйгээр 100 хувиар тооцож илүү олгосон 4,832,500.00 /дөрвөн сая найман зуун гучин хоёр мянга таван зуун/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Геологийн судалгааны ажилтай холбоотой онгоцны тийзний буцаалт 2,770,400.00 /хоёр сая долоон зуун далан мянга дөрвөн зуун/ төгрөг нь өмнөх онд байгууллагын дансанд андуурагдан орсон бөгөөд улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- "Ханбогд-2023" геофизикийн цогцолбор судалгааны ажил нь 2023 онд хийгдэж дууссан бөгөөд захиалагчийн хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 15,217,500.00 /арван таван сая хоёр зуун арван долоон мянга таван зуун/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Цалингийн зардлаас түүвэрлэн гоёмсорил хэрэгжүүлэхэд тайлант онд албан хаагчдын цалин тооцохдоо томилолтоор явсан 9 албан хаагчдад хоол, унааны зардлыг давхардуулан тооцож олгосон 989,000.00 /есөн зуун наян есөн мянган/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар үлдэх өртөггүй боловч үйл ажиллагаа нь хэвийн ашиглагдаж байгаа 195 ширхэг 711,820,700.00 /долоон зуун арван нэгэн сая найман зуун хорин мянга долоон зуун/ төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх тухай албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Аудит хийх журам"-ын 19.1-д "Шаалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAQ-73.Docx

1526180899

шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн нийт 4 төлбөрийн актыг барагдуулаагүй, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн нягтлан бодогч С.Рагчаабазарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Дашпүрэв/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Я.МАРАЛ-ЭРДЭНЭ